



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/1119

Эрдэнэт

ГТомуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, Г
тэмцэх арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27¹.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.10, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2022 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд 0-5 насны хүүхдүүдийн дунд амьсгалын замын томуу, томуу төст өвчний дэгдэлт эрчимжиж байгаа тул сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд (цэцэрлэг)-ын үйл ажиллагааг 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс 03 дугаар сарын 27-ны өдрийг дуустал хугацаанд түр зогсоосугай.

2. Дээрх хугацаанд 0-5 насны хүүхэдтэй эмэгтэйчүүд (өрх толгойлсон эцэг)-ийг цалин, урамшууллыг бууруулахгүйгээр цахимаар ажиллах нөхцөл боломжоор хангаж, хөдөлмөр зохион байгуулалт хийж ажиллахыг байгууллага, аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудад даалгасугай.

3. Амьсгалын замын томуу, томуу төст өвчний дэгдэлтийг бууруулах ажлын хүрээнд урьдчилан сэргийлэх тодорхой мэдээллүүдийг олон нийтэд хүргэх, эм хангамжийг нэмэгдүүлэх, эмчилгээ үйлчилгээний ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газар (Д.Сүхээ), Бүсийн оношилгоо эмчилгээний төв (Ц.Наран-Эрдэнэ)-д, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагуудад холбогдох үүрэг чиглэлийг өгч, мэргэжлийн байгууллагуудтай хамтран удирдлага зохион байгуулалтыг оновчтой хийж ажиллахыг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар (О.Ариунгэрэлт)-т тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлагаар хангахыг аймгийн Засаг даргын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч А.Түвшинжаргал, Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга А.Бумансор нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТЖАРГАЛ

D:(Zahiramj) A-4 doc
6122020650